

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Монгол Улсын Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/103/СТА-ТӨҮГ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
	2.1. Оршил.....	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
	2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
	2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
	2.11. Шилэн дансны мэдээлэл.....	8
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
	3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар.....	10
	3.2 Тайлагналын талаар.....	11
	3.3 Мөнгөн хөрөнгийн талаар.....	11
	3.4 Цалин хөлсний талаар.....	12
	3.5 Авлагын талаар.....	12
	3.6 Худалдан авах ажиллагааны талаар.....	13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
	4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
	4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	16
	4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	18
	4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20
	4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Я.ТӨМӨРБААТАР ТАНАА

2019.03.15 № 06/485
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Их Сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын Их Сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Их Сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Монгол Улсын Их Сургууль нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Монгол Улсын Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирлын үүрэг гүйцэтгэгч Я.Төмөрбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, мөнгөн хөрөнгө, цалин хөлс, авлага, худалдан авах ажиллагааны талаар зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Их Сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газартай байгуулсан гурвалсан гэрээг үндэслэн санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Монгол Улсын Их Сургууль нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 15-наас 3 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Голден пэйж Аудит ХХК-ийн захирал С.Оюунгэрэл хянан удирдаж, менежер Н.Очирмаа чанарын хяналтыг хийж, аудитор Б.Одгэрэл, Я.Оюун, Ц.Долгормаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Улсын Их Сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Голден пэйж Аудит ХХК-д 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 4а/436 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Монгол Улсын Их Сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Монгол Улсын Их Сургуулийн алсын хараа нь “Дэлхийн түвшний их сургууль” болоход оршино. Үүний дүнд 2024 онд чөлөөт мэдлэг буюу “либерал арт” уламжлалд суурилсан, бүс нутгийн хэмжээнд тэргүүлэх байр суурьтай судалгааны их сургууль болж, улмаар Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд багтаж орох зорилго, зорилтуудыг дэвшүүлэн зорилгоо хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Их Сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг Дээд боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-д “Их сургууль нь бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэхээс гадна судалгааны ажил зонхилсон лаборатори бүхий эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн нэгдэл хэлбэртэй дээд боловсролын сургалтын байгууллага байх бөгөөд их сургууль нь магистр, докторын сургалт дагнан эрхэлж болно” хэмээн тодорхойлсон байна.

Монгол Улсын Их Сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Монгол Улсын Их Сургуулийн удирдлага дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Дээд боловсролын тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын багц хуулиуд

Тайлант хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 193 тоот тогтоолын дагуу төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг хийсэн.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцээгүй байна. Тус байгууллагын бүрэлдэхүүнд байдаг хэвлэх үйлдвэр, брэнд дэлгүүрийн ажил гүйлгээг хэрхэн бүртгэх талаар бүртгэлийн нэгдсэн бодлого байхгүй байна. Мөн санхүүгийн програм нь тус нэгжүүдийн үйл ажиллагааны онцлогт тохироогүй, үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг тооцоолдоггүй.

Монгол Улсын Их Сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Монгол Улсын Их Сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Powersoft” програм хангамж ашигладаг байна.

Монгол Улсын Их Сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Монгол Улсын Их Сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт болон цэвэр хөрөнгийн дүн өндөр байгаа, нийт зардлыг материаллаг байдлын сууриар сонгосонтой холбоотой юм.

Монгол Улсын Их Сургуулийн 2018 оны нийт зардал 70,538.5 сая төгрөгийн 1.0 хувь буюу 705.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь эрсдэл дунд гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 9 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 8 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцлоо. Дээрх асуудлаас 1 асуудалд акт, 1 асуудалд албан шаардлага, 6 асуудалд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	/Сая төгрөгөөр/
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	6	444.3	
2	Албан шаардлага өгсөн	1	27.5	
	Дүн	8	471.8	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Анхан шатны шүүхийн шийдвэрийн дагуу ажлаас халагдсан 2 ажилтанд ажилгүй байх хугацааны цалинд 7.2 сая төгрөг олгосныг тайлант хугацааны цалингийн зардалд бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлэв.
2. Цалингийн тооцооллыг хийхдээ илүү цагийн цалин, үр дүн, шагнал урамшууллыг Засгийн газрын 1995 оны 96-р тогтоолыг үндэслэн олгоогүй, 20.3 сая төгрөгийн цалин хэтрүүлэн олгосон, төрийн албаны албан хаагчдад тогтмол цалин олгосон нь эрх үүргийг хэтрүүлсэн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Монгол Улсын Их Сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 68.9 сая төгрөгийн орлого, 56.7 сая төгрөгийн зардлын төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 45.5 сая төгрөг буюу 80.2 хувьтай байгаа нь хөрөнгийн зардал буурснаас шалтгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Монгол Улсын Их Сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Монгол Улсын Их Сургуулийн 17 нэгж бүрэлдэхүүн сургуулийн хүрээнд шилэн дансанд хугацаандаа 1771 нэгж гүйлгээ, хугацаа хоцроож 537 нэгж гүйлгээ, нийт 2308 нэгж гүйлгээ оруулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 6 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 90 хувьтай байна. Завхан сургуулийн оюутны сургалтын төлбөрийн авлагыг барагдуулах, тооцоо нийлж баталгаажуулах ажил хангалттай биелээгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол Улсын Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол Улсын Их Сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монгол Улсын Их Сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар

3.1.1 Илрүүлэлт

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцээгүй байна. Хэвлэх үйлдвэр болон брэнд дэлгүүрийн ажил гүйлгээг бүртгэх, цалингийн амралтын тооцооллын талаар бүртгэлийн нэгдсэн бодлого аргачлалгүй. Програм нь дэлгэрэнгүй бүртгэл, хураангуй бүртгэлүүдийг энгийн ойлгомжтой байдлаар татаж харах боломжгүй, дэлгэрэнгүй бүртгэлүүдийг эксел програмаар хийж гүйцэтгэдэг байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл

Хууль тогтоомж зөрчигдөх, тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй.

3.1.3 Зөвлөмж

Өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллах.

3.1.4 Байгууллагын тайлбар

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг сайжруулж байгаа, санхүүгийн програмын тендерийг 2016 оноос хойш зарлаж байгаа боловч техникийн шаардлага хангасан байгууллага одоогоор ирээгүй тендер хойшлогдсоор байна, тендерийн төсвийг жил бүр төсөвт тусгасан байгаа, энэ асуудлыг шийдвэрлэн зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

3.2 Тайлагналын талаар

3.2.1 Илрүүлэлт

Хэвлэх үйлдвэр, брэнд дэлгүүр болон бусад үйл ажиллагааны бус нэгжүүдэд тохирсон санхүүгийн програмгүй, тайлант онд үйл ажиллагааны бус орлогоор 305.0 сая төгрөг төвлөрүүлсэн боловч өртөг, зардлыг тооцоогүй байна. НӨАТ суутган төлөгч болох нөхцөл шалнуурыг хангасан боловч НӨАТ төлөгчөөр бүртгүүлээгүй нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д “нэмэгдсэн өртгийн албан татвар суутгах үүрэг үүсэх өдөр гэж энэ хуулийн 3 дугаар зүйлийн заалтад үйл ажиллагаа эрхэлж, орлого олж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн уг үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн өдрийг;” гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл

Хууль тогтоомж зөрчигдөх, тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй.

3.2.3 Зөвлөмж

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах.

3.2.4 Байгууллагын тайлбар

МУИС-ийн удирдлагад танилцуулан холбогдох хууль, дүрэм, журмын дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3.3 Мөнгөн хөрөнгийн талаар

3.3.1 Илрүүлэлт

Төрийн банкны 108801437295 тоот дансны эцсийн үлдэгдэл 5.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Аудитын үнэн зөв байдал “Аж ахуй нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, үнэн зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх” гэсэн батламж мэдэгдэл, Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ... үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл

Бүртгэлээрх хяналт алдагдах, тайлан буруу илэрхийлэгдэх.

3.3.3 Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөн ажиллах.

3.3.4 Байгууллагын тайлбар

Төрийн банкнаас гэрээний алдаатай үйл ажиллагаанд 2019.03.13-ны 19/80 тоот албан бичиг авч хавсаргав.

3.4 Цалин хөлсний талаар

3.4.1 Илрүүлэлт

Амралтын цалингийн тооцооллыг хийхдээ дундаж цалинг буруу тооцон 6.6 сая төгрөгийн зөрүүтэй бодож олгосон нь Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар батлагдсан дундаж цалин хөлс тодорхойлох журмыг баримтлан тооцоолоогүй байна.

3.4.2 Эрсдэл

Бүртгэлээрх хяналт алдагдах, тайлан буруу илэрхийлэгдэх.

3.4.3 Зөвлөмж

Дундаж цалин тооцох аргачлалыг үндэслэн тооцоолол хийж, мөрдөн ажиллах.

3.4.4 Байгууллагын тайлбар

Цаашид нэгдсэн аргачлалаар ханган зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

3.5 Авлагын талаар

3.5.1 Илрүүлэлт

Завхан сургууль нь магистрийн сургалтын төлбөрийн 127.3 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж тулган баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.5.2 Эрсдэл

Бүртгэлээрх хяналт алдагдах, тайлан буруу илэрхийлэгдэх.

3.5.3 Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөн ажиллах.

3.5.4 Байгууллагын тайлбар

Авлагыг барагдуулахаар ажлын хэсэг ажиллана.

3.6 Худалдан авах ажиллагааны талаар

3.6.1 Илрүүлэлт

Хангамжийн хэлтэс нь 2018 оны худалдан авах ажиллагааны санхүүгийн баримт тайланг дутуу ирүүлсэн, санхүүгийн баримтыг архивын нэгж болгон үдэж цэгцлээгүй. Худалдан авах ажиллагааны тайлан тооцоог хэдий хугацаанд гаргаж хүлээлгэж өгөх санхүүгийн дүрэм, журам байхгүй. Худалдан авах ажиллагааны баримтыг үдэж архивлаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49.1-т “Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална” гэж заасны дагуу архивын нэгжийг бүрдүүлэхдээ хуулийн 49.2-ыг баримтална гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.6.2 Эрсдэл

Бүртгэлээрх хяналт алдагдах, тайлан буруу илэрхийлэгдэх.

3.6.3 Зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөн ажиллах.

3.6.4 Байгууллагын тайлбар

Хуулийн заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 6 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>28,062,198,227.64</u>	<u>36,768,314,797.14</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	23,763,897,746.03	31,567,199,882.93
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	11,798,278.93	12,516,869.12
31110	Төгрөг	11,798,278.93	12,516,869.12
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	23,752,099,467.10	31,554,683,013.81
3121	Төгрөг	22,829,274,839.96	29,491,918,873.67
31213	Арилжааны банк дахь харилцах	22,829,274,839.96	29,491,918,873.67
3122	Гадаад валют	922,824,627.14	2,062,764,140.14
31223	Арилжааны банк дахь харилцах	922,824,627.14	2,062,764,140.14
33	АВЛАГА	2,024,398,802.54	2,439,613,516.75
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	497,434,567.38	285,725,804.38
335	Бусад авлага	1,526,964,235.16	2,153,887,712.37
3351	Байгууллагаас авах авлага	1,526,964,235.16	2,153,887,712.37
34	УРЬДЧИЛГАА	-	294,077,135.50
3471	Урьдчилгаа тооцоо	-	294,077,135.50
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа		97,837,135.50
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа		196,240,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,273,901,679.07	2,467,424,261.96
351	Түүхий эд материал	4,433,224.92	7,139,958.57
35110	Тусгай зориулалттай материал	2,277,190.00	6,303,300.62
35130	Эм боох материал	2,156,034.92	836,657.95
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		69,910,777.00
354	Хангамжийн материал	2,269,468,454.15	2,390,373,526.39
35410	Бичиг хэргийн материал		6,120,630.04
35420	Аж ахуйн материал	575,670,764.60	520,919,977.79
35430	Сэлбэг хэрэгсэл	120,549,051.15	116,906,951.04
35440	Түлш, шатах тослох материал	31,200.00	893,298.70
35450	Барилгын засварын материал	25,018,423.73	26,480,289.28
35460	Хүнсний материал	7,243,905.51	4,214,908.53
35470	Бусад хангамжийн материал	1,540,955,109.16	1,714,837,471.01
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>55,995,875,960.79</u>	<u>69,920,958,911.74</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	55,995,875,960.79	69,920,958,911.74
392	Биет хөрөнгө	55,848,116,238.91	65,836,689,141.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	71,423,950,933.91	51,769,824,740.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	29,555,043,854.37	415,337,658.32
39203	Авто-тээврийн хэрэгсэл	354,393,936.00	354,393,936.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	318,348,590.65	326,208,400.33
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	16,430,694,092.82	18,325,804,469.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	8,307,599,301.92	10,063,879,452.37

Монгол Улсын Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,140,663,360.77	6,724,336,819.02
39208	Хуримтлагдсан элэгдэл	3,106,096,431.44	3,422,787,727.57
39214	Бусад үндсэн хөрөнгө	294,594,077.50	175,184,948.51
39215	Хуримтлагдсан элэгдэл	177,971,230.85	116,112,001.77
39216	Дуусаагүй барилга, байгууламж	225,908,127.00	160,000,000.00
39217	Ном	2,442,971,120.14	2,671,469,468.68
393	Биет бус хөрөнгө	147,759,721.88	4,084,269,770.08
39301	Програм хангамж	257,351,389.12	328,601,676.91
39302	Хуримтлагдсан элэгдэл	109,591,667.24	154,002,616.83
39303	Бусад биет бус хөрөнгө		3,909,670,710.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>84,058,074,188.43</u>	<u>106,689,273,708.88</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>5,710,741,859.83</u>	<u>5,587,390,563.43</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,710,741,859.83	5,587,390,563.43
413	Өглөг	297,966,716.14	465,144,147.51
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	145,602,500.64	74,901,857.67
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	117,086,140.50	183,973,377.42
4136	Бусад өглөг	35,278,075.00	206,268,912.42
41361	Байгууллагад төлөх өглөг	35,278,075.00	206,017,612.60
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/		251,299.82
414	Урьдчилж орсон орлого	5,412,775,143.69	5,122,246,415.92
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	7,268,000.00	
41440	Бусад урьдчилж орсон орлого	5,405,507,143.69	5,122,246,415.92
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>78,347,332,328.60</u>	<u>101,101,883,145.45</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	78,347,332,328.60	101,101,883,145.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	16,291,864,664.47	20,201,535,374.47
51101	Өмч: - төрийн	16,291,864,664.47	20,201,535,374.47
512	Хуримтлагдсан үр дүн	44,272,135,321.65	69,024,366,033.67
51210	Өмнөх үеийн үр дүн	33,830,532,333.05	62,055,467,664.13
51220	Тайлант үеийн үр дүн	10,441,602,988.60	6,968,898,369.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,783,332,342.48	11,875,981,737.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>84,058,074,188.43</u>	<u>106,689,273,708.88</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	50,379,131,276.98	77,312,687,368.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,141,409,676.87	73,568,480,524.27
120	Нийтлэг татварын бус орлого	46,680,653,168.97	73,022,720,906.51
120003	Торгуулийн орлого	235,471,429.04	323,714,336.73
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	46,445,181,739.93	49,178,512,084.36
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,092,049,618.29	40,341,068,009.44
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,982,800,562.31	7,841,668,850.48
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	44,837,225.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,325,494,334.33	995,775,224.44
120009	Бусад орлого		23,520,494,485.42
122	Тусламжийн орлого	216,883,607.90	422,206,917.76
122001	Хандив тусламж /дотоод/	160,367,907.90	422,206,917.76
122002	Хандив тусламж /гадаад/	56,515,700.00	
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	243,872,900.00	123,552,700.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	243,872,900.00	123,552,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,237,721,600.11	3,744,206,844.59
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,895,261,500.00	2,558,500,289.75
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1,895,261,500.00	2,558,500,289.75
1330	Төсвийн захирагчдаас	1,342,460,100.11	1,176,591,019.14
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	173,984,000.00	109,922,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	1,099,472,890.11	1,066,669,019.14
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	69,003,210.00	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	9,115,535.70
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		9,115,535.70
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	39,732,912,288.37	45,189,386,156.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	39,732,912,288.37	45,189,386,156.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,259,350,101.05	44,807,339,256.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,881,751,957.59	25,637,127,427.75
210101	Үндсэн цалин	22,881,751,957.59	25,637,127,427.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,546,809,366.02	3,086,428,670.69
210201	Тэтгэврийн даатгал	1,620,696,869.29	1,964,090,972.26
210202	Тэтгэмжийн даатгал	185,222,499.35	224,467,539.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	231,528,124.18	280,584,424.60
210204	Ажилгүйдлийн даатгал	46,305,624.84	56,116,884.93
210205	Эрүүл мэндийн даатгал	463,056,248.36	561,168,849.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,099,472,890.08	1,069,301,117.42

Монгол Улсын Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210301	Гэрэл, цахилгаан	516,694,552.70	532,428,825.04
210302	Түлш, халаалт	445,898,585.74	393,966,379.31
210303	Цэвэр, бохир ус	136,879,751.64	142,905,913.07
2104	Хангамж, бараа материалын зардал	1,255,317,933.86	1,011,098,933.01
210401	Бичиг хэрэг	124,516,999.59	152,162,970.60
210402	Тээвэр, шатахуун	33,046,478.74	31,993,032.68
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,405,027.62	241,658,470.81
210404	Ном, хэвлэл	70,167,982.61	101,132,312.41
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	777,181,445.30	484,152,146.51
2105	Нормативт зардал	20,202,267.98	5,232,979.65
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,927,555.16	2,866,160.46
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,274,712.82	2,366,819.19
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	796,269,994.60	788,421,249.75
210604	Урсгал засвар	796,269,994.60	788,421,249.75
2107	Томилолт, зочны зардал	392,156,191.84	532,090,529.61
210701	Гадаад албан томилолт	65,056,999.65	127,381,727.40
210702	Дотоод албан томилолт	29,934,432.00	28,139,570.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	297,164,760.19	376,569,232.21
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,060,835,549.81	640,270,814.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,051,901,719.58	630,637,379.50
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,933,830.23	9,633,435.25
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,206,533,949.27	12,037,367,533.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	84,251,036.54	208,726,639.67
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,326,692,475.03	7,840,391,484.83
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,795,590,437.70	3,988,249,409.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	473,562,187.32	382,046,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	473,562,187.32	382,046,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	473,562,187.32	382,046,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>10,646,218,988.61</u>	<u>32,123,301,212.57</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	98,840,720.47	194,765,212.12
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	98,840,720.47	194,765,212.12
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	303,457,020.48	25,349,168,055.15
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	28,064,060.58	1,802,840,857.17
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	275,392,959.90	25,832,712.56
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		23,520,494,485.42
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(204,616,300.01)	(25,154,402,843.03)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>10,441,602,688.60</u>	<u>6,968,898,369.54</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>47,798,490,483.58</u>	<u>53,296,176,183.19</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,486,648,773.58	47,939,671,801.29
120	Нийтлэг татварын бус орлого	44,242,775,873.58	47,816,119,101.29
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	44,242,775,873.58	47,816,119,101.29
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,396,671,576.16	38,904,938,985.12
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,801,267,072.42	8,911,180,116.17
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	44,837,225.00	
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	243,872,900.00	123,552,700.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	243,872,900.00	123,552,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,311,841,710.00	5,356,504,381.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,185,871,100.00	4,895,082,081.90
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	2,185,871,100.00	4,895,082,081.90
1330	Төсвийн захирагчдаас	1,125,970,610.00	461,422,300.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	173,984,000.00	111,422,300.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	882,983,400.00	350,000,000.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	69,003,210.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>37,517,221,866.41</u>	<u>41,766,483,001.91</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	37,517,221,866.41	41,766,483,001.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37,054,673,204.59	41,432,005,811.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,924,917,566.83	25,433,893,996.36
210101	Үндсэн цалин	22,924,917,566.83	25,433,893,996.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,536,559,240.11	3,364,788,915.52
210201	Тэтгэврийн даатгал	1,614,174,061.89	1,962,793,534.05
210202	Тэтгэмжийн даатгал	184,477,035.64	280,399,076.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	230,596,294.56	504,718,337.33
210204	Ажилгүйдлийн даатгал	46,119,258.91	56,079,815.26
210205	Эрүүл мэндийн даатгал	461,192,589.11	560,798,152.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,105,829,821.08	1,066,669,019.14
210301	Гэрэл, цахилгаан	516,694,552.70	532,428,825.04
210302	Түлш, халаалт	452,255,516.74	391,334,281.03
210303	Цэвэр, бохир ус	136,879,751.64	142,905,913.07
2104	Хангамж, бараа материалын зардал	1,196,172,141.14	1,058,780,072.40
210401	Бичиг хэрэг	54,638,946.26	65,185,758.03
210402	Тээвэр, шатахуун	34,203,008.00	35,553,604.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,324,589.11	237,199,118.34
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	857,005,597.77	720,841,592.03

Монгол Улсын Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	772,622,248.98	835,508,669.28
210604	Урсгал засвар	772,622,248.98	835,508,669.28
2107	Томилолт, зочны зардал	396,204,178.60	538,575,226.48
210702	Дотоод албан томилолт	28,657,824.00	60,693,650.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	367,546,354.60	477,881,576.48
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	372,072,125.60	382,133,789.82
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	302,159,900.00	299,520,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	69,912,225.60	82,613,789.82
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,750,295,882.25	8,751,656,122.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,187,452,339.76	528,014,413.33
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,562,843,542.49	8,223,641,709.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	462,548,661.82	334,477,190.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	462,548,661.82	334,477,190.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	74,821,652.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	270,945,350.00	221,163,140.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	116,781,659.82	113,314,050.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>10,281,268,617.17</u>	<u>11,529,693,181.28</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,190,883,066.08	3,726,391,044.38
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,190,883,066.08	3,726,391,044.38
2200	Дотоод эх үүсвэрээр	8,190,883,066.08	3,726,391,044.38
222001	Тоног төхөөрөмж	550,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,190,333,066.08	3,726,391,044.38
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(8,190,883,066.08)</u>	<u>(3,726,391,044.38)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,090,385,551.09	7,803,302,136.90
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	21,673,512,194.94	23,763,897,746.03
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	23,763,897,746.03	31,567,199,882.93

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,882,266,188.17	17,783,332,342.48	33,830,532,333.05	71,496,130,863.70
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(3,590,401,523.70)			(3,590,401,523.70)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,291,864,664.47	17,783,332,342.48	33,830,532,333.05	67,905,729,340.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн			10,441,602,988.60	10,441,602,988.60
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,291,864,664.47	17,783,332,342.48	44,272,135,321.65	78,347,332,328.60
D01	2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	16,291,864,664.47	17,783,332,342.48	44,272,135,321.65	78,347,332,328.60
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,909,670,710.00		17,783,332,342.48	21,693,003,052.48
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,201,535,374.47	17,783,332,342.48	62,055,467,664.13	100,040,335,381.08
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(5,907,350,605.17)		(5,907,350,605.17)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			6,968,898,369.54	6,968,898,369.54
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,201,535,374.47	11,875,981,737.31	69,024,366,033.67	101,101,883,145.45

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	56,694,284,350.00	45,492,874,046.29	11,201,410,303.71	80.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	45,348,656,660.00	41,973,351,664.79	3,375,304,995.21	92.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,910,817,660.00	41,600,639,435.79	3,310,178,224.21	92.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27,461,649,530.00	25,628,156,619.19	1,833,492,910.81	93.3
210101	Үндсэн цалин	27,461,649,530.00	25,628,156,619.19	1,833,492,910.81	93.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,295,915,990.00	3,163,134,706.80	132,781,283.20	96.0
210201	Тэтгэврийн даатгал	2,197,277,326.67	2,108,756,471.20	88,520,855.47	96.0
210202	Тэтгэмжийн даатгал	219,727,732.67	210,875,647.12	8,852,085.55	96.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	274,659,665.83	263,594,558.90	11,065,106.93	96.0
210204	Ажилгүйдлийн даатгал	54,931,933.17	52,718,911.78	2,213,021.39	96.0
210205	Эрүүл мэндийн даатгал	549,319,331.67	527,189,117.80	22,130,213.87	96.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,134,629,470.00	1,066,669,019.14	67,960,450.86	94.0
210301	Гэрэл, цахилгаан	533,513,420.00	532,428,825.04	1,084,594.96	99.8
210302	Түлш, халаалт	433,056,650.00	391,334,281.03	41,722,368.97	90.4
210303	Цэвэр, бохир ус	168,059,400.00	142,905,913.07	25,153,486.93	85.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,279,150,550.00	1,089,304,645.96	189,845,904.04	85.2
210401	Бичиг хэрэг	114,792,020.00	66,713,208.03	48,078,811.97	58.1
210402	Тээвэр, шатахуун	42,332,400.00	35,053,604.00	7,278,796.00	82.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	313,820,120.00	237,199,118.34	76,621,001.66	75.6
210404	Ном, хэвлэл	34,163,650.00	19,321,494.56	14,842,155.44	56.6
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	774,042,360.00	731,017,221.03	43,025,138.97	94.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	969,808,960.00	843,082,750.28	126,726,209.72	86.9
210604	Урсгал засвар	969,808,960.00	843,082,750.28	126,726,209.72	86.9
2107	Томилолт, зочны зардал	657,079,140.00	566,875,921.48	90,203,218.52	86.3
210701	Гадаад албан томилолт	508,951,940.00	485,437,363.38	23,514,576.62	95.4
210702	Дотоод албан томилолт	67,518,200.00	60,693,650.00	6,824,550.00	89.9
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	80,609,000.00	20,744,908.10	59,864,091.90	25.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн	422,273,810.00	382,125,219.82	40,148,590.18	90.5

Монгол Улсын Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ажил, үйлчилгээний төлбөр, хураамж				
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	299,520,000.00	299,520,000.00	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	122,753,810.00	82,605,219.82	40,148,590.18	67.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,690,310,210.00	8,861,290,553.12	829,019,656.88	91.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,090,774,410.00	699,177,660.46	391,596,749.54	64.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,599,535,800.00	8,162,112,892.66	437,422,907.34	94.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	437,839,000.00	372,712,229.00	65,126,771.00	85.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	437,839,000.00	372,712,229.00	65,126,771.00	85.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	272,518,000.00	225,297,242.00	47,220,758.00	82.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	165,321,000.00	147,414,987.00	17,906,013.00	89.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,345,627,690.00	3,519,522,381.50	7,826,105,308.50	31.0
2200	Дотоод эх үүсвэрээр	11,345,627,690.00	3,519,522,381.50	7,826,105,308.50	31.0
220001	Барилга байгууламж	6,035,700,530.00	9,899,214.69	6,025,801,315.31	0.2
221001	Их засвар	429,400,000.00	431,160,701.00	(1,760,701.00)	100.4
222001	Тоног төхөөрөмж	2,430,600,820.00	1,855,306,532.58	575,294,287.42	76.3
223001	Бусад хөрөнгө	2,449,926,340.00	1,223,155,933.23	1,226,770,406.77	49.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	48,831,061,630.00	53,296,176,183.19	(4,465,114,553.19)	109.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,389,697,170.00	1,405,668,369.90	1,984,028,800.10	41.5
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,469,034,570.00	461,422,300.00	2,007,612,270.00	18.7
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	493,800,000.00		493,800,000.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	426,862,600.00	944,246,069.90	(517,383,469.90)	221.2
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	110,458,600.00	123,552,700.00	(13,094,100.00)	111.9
132001	Орон нутгийн төсвөөс	110,458,600.00	123,552,700.00	(13,094,100.00)	111.9
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	45,330,905,860.00	51,766,955,113.29	(6,436,049,253.29)	114.2
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,638,895,780.00	42,855,774,997.12	(3,216,879,217.12)	108.1
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,692,010,080.00	8,911,180,116.17	(3,219,170,036.17)	156.6
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		23,763,897,746.03	(23,763,897,746.03)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		31,567,199,882.93	(31,567,199,882.93)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.03.15	Аудитын нэр:	Монгол Улсын Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2019/103/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	Монгол Улсын Их Сургууль			Сая төгрөгөөр	

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл		Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5		9	10
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн програмын талаар	1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцээгүй байна. Хэвлэх үйлдвэр болон брэнд дэлгүүрийн ажил гүйлгээг бүртгэх, цалингийн амралтын тооцооллын талаар бүртгэлийн нэгдсэн бодлого аргачлалгүй. Програм нь дэлгэрэнгүй бүртгэл, хураангуй бүртгэлүүдийг энгийн ойлгомжтой байдлаар татаж харах боломжгүй, дэлгэрэнгүй бүртгэлүүдийг эксел програмаар хийж гүйцэтгэдэг.		Зөвлөмж	2019.03.12	Захирлын үүрэг гүйцэтгэгч, Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дэд захирал	Я.Төмөрбаатар Ч.Ундрэм
2	Тайлагналын талаар	1	Хэвлэх үйлдвэр, брэнд дэлгүүр болон бусад үйл ажиллагааны бус нэгжүүдэд тохирсон санхүүгийн програм бодлогогүй, 305,000.0 мянган төгрөгний орлого олсон, өртөг, зардал тооцоолдоггүй байна. НӨАТ суутган төлөгч болох нөхцөл шалгуурыг хангасан боловч НӨАТ-ын тайлан гаргадаггүй	305.0	Зөвлөмж	2019.03.12	Захирлын үүрэг гүйцэтгэгч, Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дэд захирал	Я.Төмөрбаатар Ч.Ундрэм

Монгол Улсын Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	Авлагын талаар	1	Завхан сургууль нь он дамжсан сургалтын төлбөрийн ихээхэн хэмжээний авлагатай. Тайлант оны эцэст магистрийн сургалтын төлбөрийн 127,289,280 төгрөгийн авлагыг үлдэгдлийг тооцоо нийлж тулган баталгаажуулаагүй байна.	127.3	Зөвлөмж	2019.03.12	Захирлын үүрэг гүйцэтгэгч, Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дэд захирал	Я.Төмөрбаатар Ч.Ундрэм
4	Зардлын талаар	1	Анхан шатны шүүхийн шийдвэрийн дагуу ажлаас халагдсан 2 ажилтанд ажилгүй байх хугацааны цалинд 7,216,111 төгрөг олгосныг тайлант хугацааны цалингийн зардалд бүртгэсэн.	7.2	Албан шаардлага	2019.03.12	Захирлын үүрэг гүйцэтгэгч, Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дэд захирал	Я.Төмөрбаатар Ч.Ундрэм
5	Цалин хөлсний талаар	1	Амралтын цалингийн тооцооллыг хийхдээ тухайн сард ажилласан хоногт ногдох цалинг оруулж тооцоолсноос 6,582,289 төгрөгийн зөрүүтэй тооцоолсон.	6.6	Зөвлөмж	2019.03.12	Захирлын үүрэг гүйцэтгэгч, Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дэд захирал	Я.Төмөрбаатар Ч.Ундрэм
6		1	Цалингийн тооцооллыг хийхдээ илүү цагийн цалин, үр дүн, шагнал урамшууллыг ЗГ-ын 1995 оны 96-р тогтоолыг үндэслэн олгоогүй, хэтрүүлэн олгосон, төрийн албаны албан тушаалтнуудад тогтмол цалин олгосон нь эрх үүргийг хэтрүүлсэн зөрчил илэрлээ.	20.3	Албан шаардлага	2019.03.12	Захирлын үүрэг гүйцэтгэгч, Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дэд захирал	Я.Төмөрбаатар Ч.Ундрэм
7	Худалдан авах ажиллагааны талаар	1	Хангамжийн хэлтэс нь 2018 оны худалдан авах ажиллагааны санхүүгийн баримт тайланг дутуу ирүүлсэн, санхүүгийн албанд баримт өгөх хуулийн заалт байхгүй гэсэн тайлбар хийсэн. Худалдан авах ажиллагааны тайлан тооцоог хэдий хугацаанд гаргаж хүлээлгэж өгөх санхүүгийн дүрэм, журам байхгүй. Худалдан авах ажиллагааны баримтыг үдэж архивлаагүй байна.		Зөвлөмж	2019.03.12	Захирлын үүрэг гүйцэтгэгч, Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дэд захирал	Я.Төмөрбаатар Ч.Ундрэм

Монгол Улсын Их Сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

8	Мөнгөн хөрөнгийн талаар	1	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл нь банкны үлдэгдлийн баталгаанаас зөрүүтэй тайлагнагдсан. Төрийн банкны 108801437295 тоот дансны эцсийн үлдэгдэл 5,449,315 төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан.	5.4	Зөвлөмж	2019.03.12	Захирлын үүрэг гүйцэтгэгч, Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дэд захирал	Я.Төмөрбаатар Ч.Ундрэм
		8		471.8				

